

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Хорооны 2007 оны 181 дүгээр тогтоол, “Нако түлш ” ХК-ийн 2007 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 16/07 тоот, “БиДиСек” ХК-ийн 2007 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 307 тоот хүсэлт гаргах тухай албан бичгийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Нако түлш” компанийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгэх тухай” 181 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчилсүгэй:

“3. Үнэт цаас гаргагч “Нако түлш” ХК-ийн гаргасан 3630000 ширхэг хувьцааг “БиДиСек” ХК-ийн, 5370000 ширхэг хувьцааг “Мастер фанд” ХХК-ийн өмчлөлд шилжүүлж, өмчлөх эрхийг баталгаажуулахыг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй”.

2. Мөн тогтоолд дор дурдсан агуулгатай 4, 5 дахь заалт нэмсүгэй.

“4. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны шимтгэлийг Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд зохих журмын дагуу төлөхийг “БиДиСЕК” ХК /Д.Даянбилгүүн/-д үүрэг болгосугай.”

“5. Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан дотоод журмуудыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг “Нако түлш” ХК /Ж.Бат/-д үүрэг болгосугай.”

3. Тогтоолын 3 дахь заалтын “ Хувьцааг...” гэсний ард “...хоёрдогч зах зээлд...” гэж нэмсүгэй.

4. Тогтоолын 3 дахь заалтын дэс дугаарыг “6”, 4 дэх заалтын дэс дугаарыг “7” болгон өөрчилсүгэй.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ